



Коронавирус (COVID-19) гэж юу вэ?

Коронавирус (Covid-19 эсвэл COVID-19 гэж нэрлэдэг) одоогоор нэг жилээс илүү хугацаанд бидний дунд эргэлдэж байгаа шинэ вирусны гаралтай халдварт өвчин юм. Энэ өвчин дэлхий даяар маш их гамшиг хохирол учруулж байна.




Коронавирусаар өвчилсөн ихэнх хүмүүс гэртээ үлдэж амарснаар эдгэрдэг,

гэхдээ зарим хүмүүс маш ноцтой хүндээр өвдөж, ноцтой архаг өвчинтэй болох эсвэл үхэлд ч хүрж болдог.

Коронавирусын зарим шинж тэмдгүүд:



Ханиалгаж эхлээд байнга үргэлжлэн ханиах




Өндөр халуурах




Үнэртэх эсвэл амтлах чадвар алга болох эсвэл өөрчлөгдөх

Хэрвээ та дээр дурдсан шинж тэмдэгтэй бол амьдарч байгаа газраа тусгаарлаж гадаа бүү гар. 119 рүү утасд эсвэл сорилын цаг авахаар www.gov.uk/get-coronavirus-test д зочилно уу.



Бид бүгд коронавирусын халдварын тархалтыг нүүрээ далдлан маск зүүснээр сэргийлж хязгаарлах, бусдаас зай барьж, гараа тогтмол угааж хязгаарлах ёстой.



Сайн мэдээ бол одоо таныг Коронавирусаас хамгаалах вакцин гарсан.

Вакцин хийлгэх эсэх нь таны сонголт, гэхдээ бид хийлгэхийг танд маш ихээр зөвлөж байна. Вакцины талаар илүү мэдээллийг энэ хуудасны ар талаас харна уу.



Коронавирусыны (COVID-19) эсрэг вакцины тухай

Коронавирусыны эсрэг вакцин бол тарилга юм.



Танд вакцины тарилгыг 2 удаа хийх болно, тарилга бүр хоорондоо 3-аас 12 долоо хоногийн зайтай.



Вакциныг биед аюул осолгүйг мэдэхийн тулд олон төрлийн сорил хийсэн.



Коронавирусын вакцин аливаа нэгэн амьтны бүтээгдэхүүн агуулдаггүй.



Вакцин хийлгэснээр та өөрийгөө Коронавирусаас хамгаалж байгаа юм.


Вакцин нь танд Коронавирусыг халдаадаггүй.



Вакцин хийлгэснээр таны Коронавирусаар өвдөх эрсдэл маш багасна.



Бид одоогоор вирус тээж авахаас хамгаалдаг эсэхийг сайн мэдэхгүй байна.



Вакцин нь танд Коронавирус халдаахгүй, гэхдээ танд ямарваа нэгэн зовиур илэрч болно. Та тарилга хийлгэсэнээс 1-2 хоног бага зэрэг сульдсан, ханиад хүрсэн мэт санагдаж болох нь ердийн үзэгдэл. Энэ бол вакцин таны биеийг коронавирустай тэмцэхийг зааж байгаа гэсэн үг юм.

Вакцин таныг нэн даруй хамгаалахгүй. Вакцин нь хэдэн долоо хоногийн дараа үйлчилдэг. Та өөрийгөө маш сайн хамгаалахаар хоёр тунг хоёуланг нь хийлгэх шаардлагатай.

Та вакцин хийлгэсэн ч гэсэн доорх үйлдлүүдийг үргэлжлүүлэн үйлдвэл аюулгүй байх болно:



Бусад хүмүүсээс зай барих (нийгмийн зай барих)



Нүүр хамгаалах маск зүүх



Гараа маш анхааралтай ба ойрхон угаах